МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр Дугаар А/360 Чойбалсан

Хил хамгаалалтад туслах хүчний
зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлигийн 3.8 дахь заалтыг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/04 дүгээр "аймгийн 2025 оны төсөв батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн хагас жилийн нэгдсэн зөвлөгөөнийг 2025 оны 06 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Дорнод аймгийн Баян-Уул суман дахь хилийн цэргийн 0275 дугаар ангийн байрлалд зохион байгуулахыг зөвлөлийн орлогч (хурандаа Б.Батболд)-д даалгасугай.

2.Зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүний нэрсийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Зөвлөгөөнд шаардагдах зардлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/04 дүгээр тогтоолын 2.54 дүгээрт батлагдсан "аймгийн Засаг даргын тэргүүлдэг зөвлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг" зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газар (П.Бат-Өлзий)-т зөвшөөрсүгэй.

4.Зөвлөгөөнөөр хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн 2025 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, сүүлийн хагас жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцүүлэхийг зөвлөлийн орлогч, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ЁЛ

My computer D/ Zakhiramj

2125010820

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 20-ны өдрийн
А/360 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

# ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС

| | |
|---|---|
| Зөвлөлийн дарга: | -Аймгийн Засаг дарга |
| Зөвлөлийн орлогч дарга: | -Хилийн цэргийн 0275 дугаар ангийн захирагч |
| | -Хилийн цэргийн 0132 дугаар ангийн захирагч |
| | -Хилийн цэргийн 0198 дугаар ангийн захирагч |
| | -Хилийн цэргийн 0306 дугаар ангийн захирагч |
| Нарийн бичгийн дарга: | -Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга |
| Гишүүд: | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга |
| | -Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн |
| | -Аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх |

-ТЕГ-ын Дорнод аймаг дахь Тагнуулын газрын дарга

-Аймгийн Цагдаагийн газрын дарга

-Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга

-Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

-Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

-Аймгийн Байгаль орчны газрын дарга

-Аймгийн Гаалийн газрын дарга

-Аймгийн Гадаадын иргэн, харъяатын газрын дарга

-Аймгийн Боомтын захиргааны дарга

-Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал

-Мэдээлэл холбооны сүлжээ төрийн өмчит ХХК-ны Дорнод аймгийн газрын дарга

-Баянтүмэн сумын Засаг дарга

-Чойбалсан сумын Засаг дарга

-Чулуунхороот сумын Засаг дарга

-Матад сумын Засаг дарга

-Халхгол сумын Засаг дарга

-Баян -Уул сумын Засаг дарга

-Баяндун сумын Засаг дарга

-Дашбалбар сумын Засаг дарга

---oOo---